

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2024 оны 12 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ-ий өсөлт

(2024 оны эхний 3 улирал)

5.0 хувь

Валютын нөөц

(2024 оны эцэс)

5,510 сая \$

Инфляц

(2024 оны 12 дугаар сар)

9.0 хувь

Төсвийн тэнцэл

(2024 оны эцэс)

-776 тэрбум ₮

Экспорт

(2024 оны эцэс)

15.8 тэрбум \$

Импорт

(2024 оны эцэс)

11.6 тэрбум \$

ГШХО

(2024 оны эхний 3 улирал)

2,900 сая \$

Зээлийн хүү

(2024 оны 12 дугаар сар)

16.9 хувь

Ажилчдын тоо

(2024 оны 3 дугаар улирал)

1.4 сая

*18 улирлын байдлаар ажиллах хүчний орлогооны түвшин 63 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2024 оны 3 дугаар улирал)

16.3 хувь

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2024 оны 4 дүгээр улирал)

108.4 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2024 оны 3 дугаар улирал)


10.0 хувь



Эдийн засгийн өсөлт 2024 оны эхний 3 улирлын байдлаар 5.0 хувь байна. Худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжил нэмэгдэж, татварын орлого сайн байсан нь эдийн засгийн өсөлтийг дэмжиж байна. Харин боловсруулах болон барилгын салбарын өсөлт саарч, хөдөө аж ахуйн салбарын уналт өсөлтийг хязгаарлав.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


(бодит ДНБ-ий хуримтлагдан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


(2024 оны эхний 3 улирал)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УУЛУУРХАЙ


(бодит ДНБ-ий хуримтлагдан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨДӨӨ АЖ АХУЙ

(бодит ДНБ-ий хуримтлагдан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2024 оны эхний 3 улиралд **5.0 хувиар өслөө**.
- Анхдагч салбар: Уул уурхайн салбар 11.4 хувиар тэлж, өсөлтийн 1.4 хувийг бүрдүүлсэн бол ХАА-н салбар 25.0 хувиар агшиж нийт өсөлтийг -3.5 нэгж хувиар хязгаарлалаа.
- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 2.6 хувиар өсөж өсөлтийн 0.3 нэгж хувийг;
- Үйлчилгээний салбар /худалдаа, тээвэр, үйлчилгээний бусад/ 9.6 хувиар өсөж өсөлтийн 4.6 хувийг;
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 14.6 хувиар өсөж өсөлтийн 2.1 хувийг тус тус бүрдүүлсэн байна.




- 2024 оны 3 дугаар улиралд худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт сайн байж, татварын орлого нэмэгдсэн нь өсөлтөд эергээр нөлөөлж байна.
- Уул уурхайн салбарын нийт эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө өмнөх жилийн өндөр суурийн нөлөөгөөр буурч байна.
- Харин том малын зүй бус хорогдол оны эхнээс нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбар агшив.

- Уул уурхайн салбар 2024 оны эхний 3 улиралд 11.4 хувиар тэллээ.
- Нүүрс, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал зэсийн баяжмал зэрэг уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн олборлолт нэмэгдсэнээр уул уурхайн салбарын үйлдвэрлэлд эергээр нөлөөллөө. (9 дүгээр сарын уул уурхайн бүтээгдэхүүний олборлолтын талаар [энэ](#) хэргэ харна уу.)

- ХАА-н салбар 2024 оны эхний 3 улиралд 25.0 хувиар агшлаа.
- Том малын зүй бус хорогдол 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 8.1 сая толгойд хүрч өмнөх оны мөн үеэс 4.2 сая толгой малаар нэмж хорогдсон байна. Энэ нь оны эхний (2023 оны 12 сард эцэслэсэн нийт малын тоо нь 2024 оны эхэнд байгаа нийт малын тоо болно.) нийт малын 12.6 хувьд хүрч хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл жил дараалан буурлаа.
- Нийт тариалсан талбай өнгөрсөн оноос 1.4 хувиар, хураасан улаан буудай 7.8 хувиар тус тус буурлаа.



PMI индекс хамгийн өндөр түвшинд хүрч, нийт эдийн засгийн хүлээлт эерэг байна. Харин барилга, худалдааны салбарын аж ахуйн нэгжүүд болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааны хүлээлт доогуур байна.



- Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн хүлээлтгүй илтгэх Худалдан авалтын менежерийн ерөнхий индекс (PMI) 2024 оны 3 дугаар улиралд тус индексийг тооцож эхэлсэн 2021 оноос хойших хамгийн өндөр буюу 61.0 хувьд хүрч, эдийн засаг өсөх төлөвт байна.
- Гэвч тус индекс энэ улиралд өмнөх улирлаас 3.6 нэгж хувиар өссөн нь өмнөх улирлын 5.6 нэгж хувийн өсөлтөөс буурсан үзүүлэлт байна.



- Барилгаас бусад бизнесүүдийн итгэл эерэг байна.
- Уул уурхай, түүнийг дагасан тээврийн салбарын тэлэлтэй холбоотойгоор аж үйлдвэр болон үйлчилгээний салбарын PMI индексүүд хамгийн өндөр буюу тус бүр 63 хувь байна.
- Харин барилга, дотоод худалдааны салбарын бизнесийн үйл ажиллагааны төлөв өмнөх улирлаас муудав.

- 200-гаас дээш ажиллагсадтай том аж ахуй нэгжүүдийн PMI индекс 65 хувь болж, өмнөх улирлаас 5.4 нэгж хувиар өсөв.
- Харин 50-199 ажиллагсадтай дунд хэмжээтэй аж ахуй нэгжүүдийн хувьд PMI индекс өмнөх улирлаас 4.2 нэгж хувиар буурч 49.9 хувь болж, тэдний үйл ажиллагаа агших төлөвтэй байна.
- Хэдийгээр жижиг бизнесүүдийн PMI өмнөх улирлаас 3.9 нэгж хувиар өссөн ч 47.3 хувь буюу 50-аас бага түвшинд хадгалагдаж, хүлээлт сөрөг байна.

- Бизнесүүд шинэ захиалгын тоо, үйлдвэрлэлийн хэмжээ, бараа материалын нөөц, ажил эрхлэлт нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байгаа бол нийлүүлэлтийн хүргэлтийн хугацаа сүүлийн 15 улирлын турш уртассан гэж хариулсан байна.



Дотоод эдийн засгийн идэвхжил нийт эдийн засгийн өсөлтийг тэтгэж байна.



- Төрийн болон өрхийн хэрэглээ эдийн засгийн өсөлтийг голлон тайлбарлаж байна.
- Импортын эрчимтэй өсөлт цэвэр экспортыг бууруулж, өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.

- Тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалинг нэмснээр төсвийн цалингийн зардал 2.4 дахин нэмэгдэн төрийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 37.7 хувиар өсөв.
- Цалин, тэтгэвэр тэтгэмжийн өссөний зэрэгцээ хэрэглээний зээл олголт эрчимжсэн нь өрхийн хэрэглээний 14.3 хувиар өсөлтийг дэмжив.

- Үндсэн хөрөнгийн хуримтлал 7.2 хувиар өсөв.
- Уул уурхайн хүнд машин механизмын хуримтлал болон авто зам зэрэг инженерийн барилга байгууламжийн бүтээн байгуулалтууд өсөлтөд голлох хувь нэмрийг оруулсан байна.


- Хэдийгээр нүүрсний экспортын тоо хэмжээ өссөн ч үнэ буурсан нь экспортын орлого 2.8 хувиар буурахад нөлөөлөв.
- Хэрэглээ, хөрөнгө оруулалтыг даган бараа, үйлчилгээний импорт өмнөх оны мөн үеэс 19.3 хувиар өсөв.



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 онд 5.0 хувиар өсөв. Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн олборлолтын нөлөөгөөр уул уурхайн салбарын гарц нэмэгдсэн бол мах, гурил, ээрэх, нэхмэлийн үйлдвэрлэл буурч, боловсруулах салбарын гарцад сөргөөр нөлөөллөө.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(тэрбум төгрөг)



НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(тэрбум төгрөг, ҮҮИ-ээр засварласан бодит дүн)




УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

(галлах бүтээгдэхүүнээр)

Өмнөх оноос өөрчлөлт:	2024 онд	2023 онд
Нүүрс	97.7 сая тонн	20%
Зэсийн баяжмал	1,562 мян тонн	12%
Газрын тос	42 сая баррель	-14%
Алт	126 тонн	-15%
Төмрийн хүдэр	101 сая тонн	32%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100)



- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2024 онд 32.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.0 хувиар өслөө.
- Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн олборлолт нэмэгдэж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 5.7 хувиар нэмэгдээд байна.
- Боловсруулах салбарын үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэрлэсэн дүнгээр 0.9 хувиар өслөө.

- Бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) 2024 онд өмнөх оноос 0.7 хувиар буураад байна. Үүнд:
 - Салбарын дийлэнхийг эзэлдэг уул уурхайн салбарын үйлдвэрлэл бодит дүнгээр 1.7 хувийн өсөлттэй байна.
 - Харин мах, гурил, ээрэх нэхэх үйлдвэрлэл буурснаар нийт боловсруулах үйлдвэрлэл бодит дүнгээр 6.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

- Нүүрс олборлолт 2024 онд 97.7 сая тоннд хүрч өмнөх оноос 20 хувиар нэмэгдээд байна.
- Төмрийн хүдэр, баяжмал олборлолт өмнөх оны мөн үеэс сэргэж 32 хувиар өсөөд байна.
- Зэсийн баяжмал үйлдвэрлэл 12 хувиар өсөж 1,562 мянган тоннд хүрсэн байна. Үүнд Оюутолгойн зэсийн баяжмал үйлдвэрлэл нэмэгдсэн нь нөлөөлөв.
- Харин алт болон газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс буурсан хэвээр байна.

Үйлдвэрлэгчийн үнийн индекс 2024 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар буурсан ч цар тахлын өмнөх үеэс 48.5 хувиар өслөө. Үнийн индексийн өсөлтийг бүрэлдэхүүнээр харвал:

Үнэ өссөн:

- Цахилгаан 29.3 хувиар,
- Хүнсний бүтээгдэхүүн 8.0 хувиар;
- Ундаа үйлдвэрлэлийнх 8.2 хувиар
- Тавилгаас бусад мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл 88.2 хувиар тус тус өссөн бол

Үнэ буурсан:


- Уул уурхай, олборлолт 19.5 хувиар;
- Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн үйлдвэрлэлийн үнэ 2.1 хувиар тус тус буурав.



Боловсруулах салбарын үйлдвэрлэл 2024 онд үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүнгээр 6.2 хувиар буурлаа. Үүнд боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг хөдөө аж ахуйн гаралтай мах, гурил, нэхмэл эдлэлийн үйлдвэрлэлийн биет хэмжээний бууралт голлон нөлөөлсөн байна.


МАХ

(мян тонн)




ГУРИЛ

(мян тонн)




УНДАА

(мян тонн)



НООЛУУРАН СҮЛЖМЭЛ ЭДЛЭЛ


(мян ширхэг)



- Боловсруулсан малын мах 2024 онд 54.4 мянган тонн болж, өмнөх оноос 10 хувиар өслөө.
- Боловсруулсан махны биет хэмжээ алгуур өсөж байгаа ч боловсруулах салбарын 8 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) оны эхнээс хуримтлагдсан бууралтын нөлөөгөөр өмнөх оноос 17.5 хувиар буурлаа.
- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2024 онд 144.4 мянган тонн болж, өмнөх оноос 25 хувиар буурлаа.
- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ буурснаар боловсруулах салбарын 7 орчим хувийг бүрдүүлдэг үр тарианы гурилын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оноос 27.5 хувиар буурахад голлон нөлөөллөө.
- Согууруулах болон согууруулах бүс ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2024 онд 587 мянган тоннд хүрч, өмнөх оноос 9 хувиар өслөө.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ өссөнөөр боловсруулах салбарын 24 хувийг бүрдүүлдэг ундааны бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оноос 12.3 хувиар өсөж боловсруулах салбарын өсөлтийг дэмжлээ.
- Ноолууран сүлжмэл эдлэлийн биет хэмжээ 2024 онд 368 мянган ширхэг болж, өмнөх оноос 21 хувиар буурлаа.
- Ноолууран сүлжмэл эдлэлийн тоо ширхэг буурснаар боловсруулах салбарын 7 орчим хувийг бүрдүүлдэг нэхмэлийн бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оноос 34.9 хувиар буурахад голлох нөлөө үзүүллээ.



Үйлчилгээний салбарт худалдаа, зочид буудал, нийтийн хоол зэрэг салбаруудын идэвх сайн байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын нөлөөгөөр тээврийн салбарын ачаа тээвэр өсөлттэй байна.




ТЭЭВЭР

(тээсэн ачаа, сая тонн)

	2023.12	2024.12	ӨМНӨХ ОНООС
Төмөр зам	36.5	45.8	25%
Уул уурхайн бүт.	24.0	33.6	40%
Агаар	0.009	0.010	21%
	2023.09	2024.09	
Авто зам	488	63	29%
Уул уурхайн бүт.	46.8	59.5	27%

Тэмдэглэл: Авто замын тээврийн статистик нь улирлар зарлагддаг. Эх сурвалж Үндэсний статистикийн хороо



- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар эзэлдэг.
- Тус салбарын борлуулалтын орлого 2024 оны эхний 11 сард нэрлэсэн дүнгээр 59.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 14 хувиар өссөн байна. Харин үнийн нөлөөг засварласан бодит орлогын дүн 7.6 хувийн өсөлттэй байна.

- Зочид буудал, нийтийн хоолны салбарын борлуулалт 2024 оны эхний 11 сард бодит дүнгээр 6.1 болон 8.9 хувиар тус тус өссөн байна.


- 2024 онд төмөр замаар тээвэрлэсэн ачаа 45.8 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 25 хувиар өссөн байна. Үүнээс 33.6 сая тонн буюу 73 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байна.
- Агаараар тээвэрлэсэн ачаа өмнөх оноос 21 хувийн өсөлттэй байна.
- Авто замаар 2024 оны эхний 3 улиралд 63.0 сая тонн ачаа тээвэрлэсний 59.5 сая нь уул уурхайн бүтээгдэхүүн байна.

- Монгол Улсын хилээр орсон жуулчдын тоо 2024 онд 727 мянгад хүрч, өмнөх оноос 22 хувиар нэмэгдсэн байна.



2024 онд гадаад худалдааны бараа эргэлт 27.4 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 4.2 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.


ЭКСПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Экспорт 2024 онд 15,783 сая ам.долларт хүрч өмнөх оноос 3.8 хувиар өслөө.
- Нийт экспортын 93 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспорт дангаараа 55 хувийг бүрдүүлж байна.


ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспортын орлого 8,700 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 2.3 хувиар буурлаа.
- Зэсийн баямжлын экспортын орлого 3,318 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 26.5 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 899 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 18.6 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 601 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 35.8 хувиар өслөө.


ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- 2024 онд импорт 11,612 сая ам.долларт хүрч өмнөх оноос 25.5 хувиар өссөн байна.
- Нийт импортын 19.7 хувийг тоног төхөөрөмж, 16.7 хувийг нефть, 9.1 хувийг суудлын автомашин эзэлж байна.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар


- Тоног төхөөрөмжийн импорт 2,284 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 40.1 хувиар өслөө.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 1,939 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 18.8 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 1,062 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 57.3 хувиар өслөө.



2024 онд байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 93 хувийг, тэр дундаа нүүрс болон зэсийн баяжмал дангаараа 88 хувийг бүрдүүллээ.

НҮҮРС


(саятонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЗЭСИЙН БАЯЖМАЛ


(мян тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТӨМРИЙН ХҮДЭР


(мян тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГАЗРЫН ТОС

(мян баррель)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспорт 2024 онд 83.7 сая тоннд хүрч, өмнөх оноос 20 хувиар өслөө.
- Нүүрсний экспорт 2023 оны эцэст 69.9 сая тоннд хүрч, цар тахлын өмнөх үеэс 90 хувиар өссөн.

- Зэсийн баяжмалын экспорт 2024 онд 1,695 мянган тоннд хүрч, өмнөх оноос 11 хувиар өслөө.
- Зэсийн баяжмалын экспорт 2023 оны эцэст 1,525 мянган тоннд хүрч, цар тахлын үеэс өмнөх үеэс 9 хувиар өслөө.


- Төмрийн хүдрийн экспорт 2024 онд 7,492 мянган тоннд хүрч, өмнөх оноос 32 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспорт 2023 эцэст 5,675 мянган тоннд хүрч, өмнөх үеэс 33 хувиар өслөө.

- Газрын тосны экспорт 2024 онд 4,074 мянган баррельд хүрч, өмнөх оноос 14 хувиар буурлаа.



2024 онд голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.


МАЛЫН МАХ (сая ам.доллар)



Эх сурвалж Гаалийн ерөнхий газар

- Малын махны экспорт 2024 онд 267 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 14 хувиар буурлаа.
- Тэр дундаа боловсруулсан махны экспорт өмнөх оны мөн үеэс 3 дахин багассан байна.


АРЬС ШИР (сая ам.доллар)



Эх сурвалж Гаалийн ерөнхий газар

- Боловсруулсан арьс ширний экспорт 2024 онд 2.3 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 5 хувиар буурлаа.


НООЛУУР (сая ам.доллар)



Эх сурвалж Гаалийн ерөнхий газар

- Ноолуурын экспорт 2024 онд 321 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 11 хувиар буурлаа.

НООС (сая ам.доллар)



Эх сурвалж Гаалийн ерөнхий газар


- Ноосны экспорт 2024 онд 4.2 сая ам.долларт хүрч, оноос 17 хувиар буурлаа.



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС


(\$/тонн, Сингапурын бирждэж Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

ЗЭС


(\$/тонн, Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

ТӨМРИЙН БАЯЖМАЛ


(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмал)



Эх сурвалж: Блүүмберг

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Брент)



Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2024 оны 12 дугаар сарын дундаж үнэ 203 ам.долларт хүрч, өмнөх сараас 1 хувиар, өмнөх оны мөн үеэс 39 хувиар буурсан байна.


- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2024 оны 12 дугаар сарын дунджаар 8,913 ам.доллар хүрч, өмнөх оны мөн үеэс 6 хувиар өссөн байна.

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2024 оны 12 дугаар дундаж үнэ 105 ам.долларт хүрч, өмнөх сараас 1 хувиар, өмнөх оны мөн үеэс 23 хувиар буурсан байна.

- Брент газрын тосны 2024 оны 12 дугаар сарын дундаж үнэ 75 ам.долларт хүрч өмнөх сараас 1 хувиар буурсан хэдий ч өмнөх оны мөн үеэс 2 хувиар өслөө.



Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2024 оны 12 дугаар сарын байдлаар нийт 37.3 сая тонн нүүрс, 3.1 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 5.4 мянган тонн зэсийн баяжмал, 17.6 мянган тонн жоншны хүдэр болон баяжмалыг тус тус арилжаалаад байна.



- 2024 оны 12 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 37.3 сая тонн нүүрс арилжиж, 4.8 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2024 онд сард 22.4 сая тонн нүүрс арилжиж, 2.4 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2024 оны 12 дугаар сард 0.7 сая тонн нүүрс борлууллаа.



- 2024 оны 12 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 37 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 37 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 12 дугаар сард хэлцлийн доод үнэ 25 ам.доллар, дээд үнэ 73 ам.долларт хүрэв.

- 2024 оны 12 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дугаар сараас хойш нийт 3.1 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 224.0 сая ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2024 онд 2.4 сая тонн төмрийг арилжаалж, 167 сая ам.долларын орлого олжээ.

- Төмрийн хүдэр болон баяжмалын 12 дугаар сарын дуудах дундаж үнэ 63 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 63 ам.доллар болж өсөв.
- Төмрийн төрлөөс хамааран 12 дугаар сард хэлцлийн доод үнэ 56 ам.доллар, дээд үнэ 85 ам.долларт хүрэв.



Улаанбаатар хот гадаад бонд гаргасантай холбоотойгоор 2024 оны эхний 10 сарын байдлаар алдагдалтай байсан төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 11 сарын байдлаар 38 сая ам.долларын ашигтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2024 оны эцэст 5,510 сая ам.доллар болж, түүхэн дээд түвшинд хүрлээ.



- Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 11 сард 38 сая ам.долларын ашигтай гарлаа. Төлбөрийн тэнцэл ашигтай гарахад Улаанбаатар хотын гадаад бондын орох урсгал нөлөөллөө.
 - Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 1.2 тэрбум ам.доллароор нэмэгдсэн ч импортын өсөлт 2.5 тэрбум ам.долларт хүрснээр урсгал данс алдагдалтай байна.
 - Төлбөрийн тэнцлийн шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал* 2024 оны эхний 11 сард 2.4 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 0.6 тэрбум ам.доллароор өссөн байна.
- *Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон эзэлийн эргэн төлөлтэй холбоотой гарж урсгалыг хассан дүн

- Гадаад валютын улсын нөөц 2024 оны эцэст 5,510 сая ам.доллар болж, өмнөх сараас 545 сая ам.доллароор, өмнөх оны эцсээс 588 сая ам.доллароор тус тус өсөж, түүхэн дээд түвшинд хүрлээ.

- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2024 оны 12 дугаар сард өдөрт дунджаар 0.1 төгрөгөөр суларснаар оны эцсийн ханш 3,420.50 төгрөгт хүрлээ.
- Ингэснээр 2024 оны дундаж ханш 3,390 төгрөгт хүрч, өмнөх оны дунджаас 76 төгрөг буюу 2.2 хувиар чангарлаа.


- Төв банк 2024 оны 12 дугаар сард 549 сая ам.долларыг зах зээлд нийлүүлснээр 2024 оны нийт дуудлага худалдааны дүн 6,553 сая ам.долларт хүрлээ.
- Энэ нь 2023 онтой харьцуулахад 33.1 хувиар буюу 2,652 сая ам.доллароор өндөр дүн боллоо.



Инфляц 2024 оны 12 дугаар сард 9.0 хувьд хүрч, өмнөх сараас 0.9 нэгж хувиар эрчимжлээ. Инфляц өмнөх сараас эрчимжихэд хүнс, хувцас, түрээсийн зардал, автомашины үнийн өсөлт голлон нөлөөлжээ. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад 1.2 хувиар өссөн байна.

ЖИЛИЙН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

САРЫН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

СУУРЬ ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Инфляц 2024 оны 12 дугаар сард улсын хэмжээнд 9.0 хувьд гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.6 нэгж хувь (29.1 хувь)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 6.4 нэгж хувь буюу 70.9 хувийг эзэлж байна.

- 2024 оны 12 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.2 хувиар өсөв.
- Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.2 хувиар өсөхөд хүнсний бараа 2.2 хувиар, суудлын автомашины үнэ 3.4 хувиар, хувцас, бөс бараа, гутлын үнэ 1.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2024 оны 12 дугаар сард суурь инфляц 7.8 хувь гарч, нийт инфляцын 5.2 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн сар өссөн үзүүлэлттэй байна.

- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 2024 оны 12 дугаар сард жилийн инфляцын 17.1 хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар өсжээ.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар өсөв.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 21.6 хувиар өслөө.



Олон улсад чингэлэг тээврийн үнэ өндөр байгаа нь импортын инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна. Хүнсний үнийн индекс 2024 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ХҮНСНИЙ БА ХҮНСНИЙ БУС ИНФЛЯЦ

(хувь)




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Хүнсний инфляц 2024 оны 12 дугаар сард 8.7 хувь болж, нийт инфляцын 2.5 нэгж хувийг бүрдүүлэв. Хүнсний инфляц өмнөх сараас 0.4 нэгж хувиар эрчимжихэд мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт голлох нөлөө үзүүллээ.
- Хүнсний бус инфляц 9.1 хувь болж, нийт инфляцын 6.5 нэгж хувийг бүрдүүллээ. Хүнсний бус инфляц өмнөх сараас 0.5 нэгж хувиар өсөхөд хувцас, орон сууцны түрээс, автомашины үнийн өсөлт нөлөөлөв.

ИМПОРТЫН ИНФЛЯЦ БА ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ

(хувь)




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Монголбанк

- Төгрөгийн амдоллартой харьцах ханш 2024 оны 12 дугаар сард дунджаар 3,418 төгрөг болж, өмнөх сараас 0.2 хувиар сулрав.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ өмнөх сараас 0.9 хувиар өссөн байна.

ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН ҮНЭ

(1000\$/40 фут конгейнер)



Эх сурвалж: Drewry World Container Index

- Дэлхийн чингэлэг тээврийн үнэ Улаан тэнгис/Суэцийн сувагт үүсээд буй халдлагаас үүдэлтэйгээр өсөөд байна.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн байдлаар 40 фут конгейнер тутамд 3,986 амдоллар буюу өмнөх оны мөн үеэс 30 хувиар өндөр байна. Энэ нь цар тахлаас өмнөх 2019 оны дундаж үеэс 181 хувиар өндөр үзүүлэлт юм.
- Чингэлэг тээврийн үнэ өндөр хэвээр байгаа нь нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна.

ХҮНСНИЙ ҮНИЙН ИНДЕКС

(хувь)




Эх сурвалж: FAO

- НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс нь хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2024 оны 12 дугаар сард 127.0 болж, өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар өссөн бол, өмнөх сараас 0.5 хувиар буурсан байна.
- Сүүлийн сар дэлхийн зах зээл дээр сүүн бүтээгдэхүүн, ургамлын тос, үр тариа, элсэн чихрийн үнэ буурсан бол махны үнэ өсжээ.



Монгол Улсын нэгдсэн төсөв 2024 оны 12 дүгээр сарын байдлаар 776 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсөв алдагдалтай гарахад төсвийн зарлагын өсөлт голлон нөлөөллөө.


ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ
(их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- Нэгдсэн төсөв 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 776 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, төсвийн тэнцэл өмнөх оноос 1.5 их наяд төгрөгөөр буурлаа.


ТӨСВИЙН ОРЛОГО
(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- Орлого 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 31.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 7.0 их наяд төгрөг буюу 29.0 хувиар нэмэгдсэн байна.
- Дээрх өсөлтөд орлогын албан татвар 3.2 их наяд төгрөг буюу 54.8 хувиар, НӨАТ 1.1 их наяд төгрөг буюу 22.9 хувиар, нийгмийн даатгалын орлого 757 тэрбум төгрөг буюу 19.2 хувиар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн бол АМНАТ-ийн орлого 317 тэрбум төгрөгөөр буюу 7.6 хувиар буураад байна.

2024 ОНД НЭМЭГДСЭН ГОЛЛОХ ЗАРЛАГУУД
(зарлагын ангиллаар, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- Зарлага 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 30.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 7.9 их наяд төгрөг буюу 31.2 хувиар нэмэгдсэн байна.
- 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс цалин, тэтгэврийг дунджаар 10 хувиар нэмэгдүүлсэн.
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудал, эдийн засгийн суурийг тэлэх эрчим хүч, дэд бүтэц аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг эхлүүлэхээр төлөвлөж, 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдүүлээд байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)
(Эүүн тэнцлэг: их наяд төгрөг, ДНБ-д эзлэх хувь)




Эх сурвалж: Сангийн яам

- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 30.8 их наяд төгрөгт хүрч, ДНБ-д харьцуулсан харьцаа 38.9 хувьд хүрээд байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.




Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 12 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар өсөж, 43.3 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2024 оны 12 дугаар сард 36.8 их наяд төгрөгт хүрч, 35.5 хувиар өссөн байна.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж Монголбанк

ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж Монголбанк

ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (хувь)



Эх сурвалж Монголбанк

ХҮҮГИЙН ТҮВШИН (жигнэсэн дундаж хувь)



Эх сурвалж Монголбанк

- Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 12 дугаар сарын эцэст 43.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 15.2 хувиар өссөн байна.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 13.1 нэгж хувь, төгрөгийн харилцах 4.7 нэгж хувь, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.2 нэгж хувь, гадаад валютын харилцах -2.4 нэгж хувь, гадаад валютын хадгаламж -0.4 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.



- Нийт хадгаламж 27.0 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 21.7 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 22.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 28.8 хувиар, өмнөх сараас 4.7 хувиар тус тус өслөө.
- Гадаад валютын хадгаламж 4.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар буурсан бол өмнөх сараас 7.2 хувиар өслөө.

- Банкнүүдн зээлийн үлдэгдэл 2024 оны 12 дугаар сарын эцэст 36.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 35.5 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.3 нэгж хувиар буурсан байна.

- Банкнүүдн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 12 дугаар сард 16.9 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өслөө.
- Банкнүүдн шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 12 дугаар сард 11.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өссөн бол өмнөх сараас 0.1 нэгж хувиар өслөө.



Эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр хөдөлмөрийн зах зээл идэвхжиж 2024 оны 3 дугаар улиралд ажилчдын тоо 1 сая 360 мянгад, ажиллах хүчний оролцооны түвшин 63.0 хувьд хүрлээ.



- Ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 34 мянга буюу 3 хувиар нэмэгдэж 1 сая 360.3 мянгад хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 72.4 мянгаар өндөр үзүүлэлт юм.
- 2024 оны 3 дугаар улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 13.9 мянгаар, эмэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 20.2 мянгаар тус тус өссөн байна.





- Ажилчдын тооны өсөлтөд үйлчилгээ ба бусад, худалдаа, тээвэр, уул уурхай, барилгын салбарын ажилчид нэмэгдсэн нь зөргөөр нөлөөлсөн байна.
- Харин хөдөө аж ахуйн салбарын ажилчид, мөн боловсруулах, ус, цахилгааны салбарын ажилчдын тоо буурсан нь сөргөөр нөлөөллөө.

- Ажиллах хүчний оролцооны түвшин 63.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.4 нэгж хувиар, цар тахлын өмнөх үеэс 2.9 нэгж хувиар өслөө.
- Харин ажилгүй иргэдийн тоо 2024 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 14 мянган хүнээр өсөж 823 мянгад хүрсэн байна. Ингэснээр ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар өсөж 6.1 хувьд хүрчээ.

- Дундаж цалингийн хэмжээ 2024 оны 3 дугаар улиралд байдлаар өмнөх оны мөн үеэс 23 хувиар өсөж, 2 сая 480 мянган төгрөгт хүрлээ.
- Улсын медиан цалин 2024 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 30 хувиар өсөж, 2 сая 24 мянган төгрөг болов. Энэ нь дундаж цалингаас 468 мянган төгрөгөөр бага байна.
- Салбараар авч үзвэл уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараа тэргүүлж улсын дунджаас 2.1 дахин өндөр байна.



Өрхийн нэрлэсэн дундаж орлого 2.6 сая төгрөг боллоо. Гэсэн хэдий ч орлого багатай, цалингийн орлогогүй иргэдийн бодит орлого буурах эрсдэл хэвээр байна.



- Өрхийн бодит орлого 10 хувиар өсөж, өсөлт суурийн нөлөөгөөр саарлаа.
- Өсөлтөд иргэдийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс 234 мянган төгрөгөөр, ХАА-н орлого 87 мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 69 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлөв.

- Өрхийн дундаж бодит орлогод эзлэх цалингийн хэмжээ 55.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар нэмэгдсэн байна.
- Үүнд дундаж цалингийн өсөлтөөс гадна хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн нь нөлөөлж байна.

- Бага орлоготой өрхийн дундаж орлогод өсөлт төдийлөн ажиглагдахгүй байна.
- Нийт өрхийн 35.7 хувийг 1.6 сая төгрөгөөс бага орлоготой өрхүүд бүрдүүлж байгаа ба тэдгээрийн сарын дундаж орлого нэрлэсэн дүнгээр 967 мянган төгрөг байна.
- Харин 1.6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого 3,278 мянган төгрөг байна.


- Нийслэлийн өрхийн дундаж орлого 3 сая төгрөгт хүрсэн бол хөдөө орон нутгийн өрхийн орлого бага байна.
- Цалингийн орлого нийслэлийн өрхийн орлогын 61.2 хувийг бүрдүүлж байгаа бол хөдөөгийн өрхийн орлогын 18.7 хувийг бүрдүүлж байна.



ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 3.1 хувь байна. Төв банкнаас бодлогын хүүг 2024 оны 10 дугаар сард 2 нэгж хувиар өсгөж, 21 хувьд хүргэв. Харин инфляцын түвшин 2024 оны 12 дугаар сард 9.5 хувьд хүрч, өмнөх сараас 0.6 нэгж хувиар өслөө.

БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТ

(хувь)




Эх сурвалж: Блүүмберг

- ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 3 дугаар улиралд 3.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.6 нэгж хувиар буурлаа.
- Цэрэг, армийн зардлын өсөлттэй холбоотой төсвийн зардал тэлэлтээс үүдэн идэвхжээд байсан эдийн засгийн өсөлт ийнхүү саарч, 2023 оны эхний улирлаас хойш доод үзүүлэлтэд хүрлээ.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(хувь тухайн сар)




Эх сурвалж: Блүүмберг

- 2024 оны 11 сарын байдлаар экспорт 386 тэрбум ам.доллар, импорт 268 тэрбум ам.долларт хүрч худалдааны тэнцэл 118 тэрбум ам.долларын ашигтай байна.
- Экспорт 2024 оны 11 дүгээр сард өмнөх сараас 5.5 хувиар буурлаа.
- Импорт 2024 оны 11 дүгээр сард өмнөх сараас 6.9 хувиар өслөө.

ИНФЛЯЦ

(хувь)




Эх сурвалж: Блүүмберг

- Инфляцын түвшин 2024 оны 12 дугаар сард 9.5 хувь болж, өмнөх сараас 0.6 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 2.1 нэг хувиар тус тус өссөн байна.
- ОХУ-ын инфляц зорилтот түвшин 4 хувиас өндөр хэвээр байна.
- ОХУ-ын Төв банкнаас 10 дугаар сарын 25-ны өдөр бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 21 хувьд хүргэх шийдвэр гаргалаа.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)

(НЭГЖ ХУВЬ)




Эх сурвалж: Блүүмберг

- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2024 оны 12 дугаар сард 50.8 болж, өмнөх сараас 0.5 нэгжээр буурлаа.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 3.7 хувь болж, өмнөх сараас 1.1 нэгж хувиар буурлаа.




БНХАУ-ын эдийн засгийн 2024 оны эхний 3 улирлын өсөлт 4.8 хувьд байна. 2024 оны 11 дүгээр сард экспортын өсөлт саарч, импортын агшилт тэллээ.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ




- БНХАУ-ын эдийн засаг 2024 оны 3 дугаар улиралд 4.6 хувиар өссөнөөр эхний 3 улирлын байдлаар өсөлт 4.8 хувьд хүрлээ.
- Экспортын өсөлт 2024 оны 12 дугаар сард 10.7 хувьд хүрснээр 2024 оны нийт экспорт \$3.58 их наяд болж, өмнөх оноос 5.9 хувиар өслөө.
- Импортын өсөлт 2024 оны 12 дугаар сард 1.0 хувьд хүрснээр 2024 оны нийт импорт \$2.59 их наяд болж, өмнөх оноос 1.1 хувиар өслөө.

АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ




- Аж үйлдвэрийн гарцын өсөлт 2024 оны 12 дугаар сард 6.2 хувьд хүрч эрчимжсэнээр 2024 оны өсөлт 5.8 хувьд хүрч, 2023 оны 4.6 хувийн өсөлтөөс өндөр гарлаа.
- Жижиглэн худалдааны өсөлт 2024 оны 12 дугаар сард, 3.7 хувьд хүрч эрчимжсэнээр 2024 оны өсөлт 3.5 хувьд хүрч, 2023 оны 7.2 хувийн өсөлтөөс бага гарлаа.

ИНФЛЯЦ



- Хэрэглээний үнийн индексийн өсөлт 2024 оны 12 дугаар сард сүүлийн 9 сарын хамгийн бага түвшин 0.1 хувьд хүрлээ.
- Харин үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2024 оны 12 дугаар сард -2.3 хувьтай гарч, бууралтын хурд саарлаа.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2024 оны 12 дугаар сард 50.1 болж, 3 сар дараалан тэлэлтийг илтгэх босго утга 50-ийг давав.
- Аж үйлдвэрийн бус салбарын худалдан авалтын менежерийн индекс болон нэгдсэн индекс 52.2 болж, өмнөх сараас 2.2 болон 1.4 нэгжээр тус тус өслөө.

Тус индекс нь богино хугацааны идэвхжилтийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ